

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд Эдийн-Засгийн Харилиан Туслах Зөвлөлийн зарчмын дагуу ах^дуу ёсоор харилцан туслах, аль алиндаа ашигтай 'байх зарчмын ундсэн дээр эдийн засаг, шикжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаагаа цаашид хэлбэрэлтгүй хөгжүүлэн бэхжуулнэ.

Гуравдугаар зүйл

'Хэлэлиэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд соёл, шинжлэх ухаан, тухайлбал боловсрол, эруулийг хамгаалах, утга зохиол, урлаг, хэвлэл, радио, зурагт радио, кино болон биеийн тамир спортын салбарі хамтын ажиллагаагаа цаашид улам өргөтгөн хөгжүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд тус хоёр орны олон нийтийн байгууллагуудын хамтын өргөн ажиллагааг хоёр ард түмэн бие биеийнхээ аж амьдрал, социалист бүтээн байгуулалтын туршлагатай танилгах чухал арга хэрэглуур гэж үзэж бух талаар хөхүүлэн дэмжинэ.

Тавдугаар зүйл

Хэлэлиэн Тохирогч Эрхэм хоёр Этгээд бух хувьсгалт,-дэвшилт хучний гол өмөг тушиг болсон дэлхийн социалист хамтын нөхөрлөлийн хучин чадал, нэгдэл нягтралыг улам бүр бэхжүүлэхийн тулд бухий л арга хэмжээг цаашид авах болно.